



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
**ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
 ЗАХИРАМЖ**

2021 оны 09 сарын 30 өдөр

Дугаар А/143

Шивээговь сум

Сумын төвийн камержуулалтын ажлын  
 гүйцэтгэлийг хүлээж авах комисс  
 томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам батлах тухай 2019 оны 271 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.12 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын 2021 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих Сумын төвийн камержуулалтын ажлыг хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Комиссын дарга:	О.Болормаа (Хууль, эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн)
Нарийн бичгийн дарга:	Ц.Замбага (Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдаа авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)
Гишүүд:	Б.Шинэбаяр (Цагдаагийн хошууч цагдаагийн хэсгийн дарга) Ж.Баярцэцэг (Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын менежер) Т.Эрдэнэбилэг (Шивээ-Овоо хувьцаат компанийн Мэдээлэл технологийн ахлах инженер)

2. Сумын төвийн камержуулалтын ажлын даалгаварт тусгагдсан тоо хэмжээ, дагалдах хэрэгсэл болон 52 инчийн телевизорыг цагдаагийн байгууллагын хөрөнгөнд бүртгэж, ашиглалт хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг цагдаагийн хошууч цагдаагийн хэсгийн дарга (Б.Шинэбаяр)-т үүрэг болгосугай.

3. Камерын үндсэн болон дагалдах хэрэгслийн нэрсийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

4. Гүйцэтгэлийн ажлыг захиалагчаас гаргасан ажлын даалгаврын дагуу шаардлага хангасан тоног төхөөрөмж, бараа материалыг хүлээн авч, акт үйлдэн холбогдох баримтыг хавсарган хүлээлцэхийг комиссын дарга (О.Болормаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П. ГАНЧИМЭГ